



НОГООН ХӨГЖИЛД хувийн хэвшлийн оролцоо



М.Хосбаяр, Ахлах мэргэжилтэн,
МҮХАҮТ



Цэвэр хөгжил, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих газар



Дэлхий нийтийн хандлага

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP): **Ногоон эдийн засаг**

НҮБ-ын Үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих байгууллага (UNIDO):

Ногоон үйлдвэрлэл

НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын эдийн засаг,

нийгмийн комисс (UNESCAP): **Ногоон өсөлт**

Монгол улс: **Ногоон хөгжил**



Green Economy



Ray Shannon



Ногоон санхүүжилт

- АХБ-ны уур амьсгалын өөрчлөлтийн сан-
Green Climate Fund 1.5 billion USD
- [Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк \(ЕСБХБ\)](#) -ХААН Банктай байгуулсан. Тогтвортой эрчим хүчний төслийг санхүүжүүлэх 10 сая ам.долларын гэрээ
- ОУУАХОС-аас “Монгол улсын сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд шаардлагатай 30 сая ам.долларын



Яагаад ногоон хөгжлийн тухай ярих болов: Монгол улс

Монгол улсНҮБ-ээс гаргасан хүний хөгжлийн индэкс 0,65 болон нэг хүнд ноогдох экологийн ул мөр 5,53 га харьцуулж Монгол улсын эдийн засгийн байдлыг цэнхэр өнгөөр харууллаа



National Rankings of Green Investments and Markets

THE GLOBAL GREEN ECONOMY INDEX™

GGEI 2014

Measuring National Performance in the Green Economy

4th Edition – October 2014

1. Манлайлал ба уур амьсгалын өөрчлөлт
3. Зах зээл ба хөрөнгө оруулалт
2. Үйлдвэрлэлийн салбарууд-Efficiency sectors
4. Байгаль орчин ба байгалийн баялаг

COUNTRY RESULTS

PERCEPTION RANK	COUNTRY	SCORE	PERFORMANCE RANK	COUNTRY	SCORE
01	Germany	93.6	01	Sweden	68.1
02	Denmark	92.8	02	Norway	65.9
03	Sweden	90.2	03	Costa Rica	64.2
04	Norway	84.8	04	Germany	63.6
05	Netherlands	84.0	05	Denmark	63.2
06	United States	76.2	06	Switzerland	63.1
50	Mozambique	29.8	50	Slovakia	43.0
51	Thailand	29.3	51	Panama	41.5
52	Czech Republic	29.2	52	Morocco	41.5
53	Cambodia	28.9	53	Mozambique	41.0
54	Ghana	28.7	54	Indonesia	40.3
55	Burkina Faso	28.5	55	China	40.1
56	Slovakia	28.2	56	Poland	37.1
57	Mongolia	27.7	57	Senegal	33.4
58	Uruguay	27.6	58	Qatar	33.3
59	Panama	27.4	59	Vietnam	32.2
60	Senegal	27.3	60	Mongolia	29.5

Танхимаас санал оруулсан бодлогын баримт бичгүүд

- Хүрэн эдийн засгаас Ногоон эдийн засагт шилжих хөтөлбөр 2010 онд /Засгийн газарт/
- Үндэсний ногоон хөгжлийн хөтөлбөрт санал /оролцогч/
- Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа материал худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах санал /ЭЗЯ/
- ЗГ 146-р тогтоолыг хэрэгжүүлэх санал /БОНХАЖЯ/
- Органик хүнсний тухай хуульд санал /ХХААЯ/
- Байгаль хамгаалах сантай хамтран ажиллах гэрээ
- НЗДТГ, УБ хотын ЗАА-тай хамтран ажиллах санал г.м
- Аймгуудын ЗДТГ-т Ногоон хөгжлийн бодлого, танилцуулах сургалтууд 5 аймагт



Үндэсний хэмжээнд зохион байгуулсан



Танхимын санаачилга

МҮХАҮТ-ын санаачилга 2010

“Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих 5х20” хөтөлбөр:
20/20/20/20/20 буюу 2020 он дуустал хугацаанд 2010 оны түвшинтэй харьцуулахад:

- ДНБ-нд харьцуулсан хүлэмжийн хийн ялгарлыг 20 хувиар бууруулах,
- Эрчим хүчний үр ашгийг 20 хувиар нэмэгдүүлэх,
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 20 хувьд хүргэх,
- Байгальд оруулах хөрөнгө оруулалтыг 20 хувиар нэмэгдүүлэх,
- “Ногоон худалдан авалт”-ыг Засгийн газар, орон нутгийн төсвийн худалдан авалтын 20 хувьд хүргэх.

ОРГАНИК
БҮТЭЭГДЭХҮҮН
CERTIFIED ORGANIC



Хэрэгжүүлсэн төслүүд



Аргазүйн баримтууд

- Ногоон бизнес, ногоон эдийн засгийн CD
- “Ногоон оффис” аргачлал
- “Ногоон ном 2008, 2010”
- “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх олгох журам
- “Эко үр ашгийн индикаторууд: Нөөцийн ашиглалтын үр ашиг ба эдийн засгийн хөгжлийн байгаль орчны нөлөөллийг үнэлэх нь” зөвлөмж
- Усны нөөц баялгийг ашиглахад иж бүрэн хандахад чиглэсэн, эко системүүдийн үйлчлэлийн төлбөрийн талаарх зөвлөмжүүд
- Үйлдвэрийн газрын байгаль орчны менежмент
- Үйлдвэрийн газрын эрчим хүчний менежмент
- Эко дизайны гарын авлага
- Цэвэр үйлдвэрлэлийн үнэлгээний гарын авлага
- Цэвэр үйлдвэрлэлийн хялбарчилсан гарын авлага
- ESCO бизнесийн гарын авлага
- “NO water NO life, No water No business” эрдэм шинжилгээний эмхэтгэл
- “Тогтвортой хөгжил” сар тутмын электрон сэтгүүл

Танхимын ногоон худалдан авалтын журам

МУХАУТ-ын Даргын 2013 оны 44 дугаар
сарын 24 өдрийн Хурал Тухайн
1 дүгээр Хавсралт

НОГООН ХУДАЛДАН АВАЛТЫН ЖУРАМ

1. Худалдан авалтад дараах ерөнхий зарчмуудыг баримтлана. Үүнд:

- Аливаа бүтээгдэхүүний үйлдвэрлэл ямагт байгаль орчинд хор нөлөө үзүүлж байдгийг анхаарч ухаалаг худалдан авалт хийхийг эрмэлзэх
- Тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал нь худалдан авалтын зардлаас ямагт олон дахин их байдгийг анхаарч үр ашигтай, ашиглалтын зардал багатай төхөөрөмж сонгох:
- ENERGY STAR® логотой буюу түүнээс илүү үзүүлэлттэй эрчим хүчний хэмнэлттэй,
- дахин ашиглах, цэнэглэх боломжтой,
- олон үйлдэлтэй,
- засварлах боломжтой
- Бичиг хэргийн хэрэгслийг худалдаж авахдаа нийтлэг байдлаар худалдан авалт хийж хуваарилах биш, хэрэгцээ, шаардлагад үндэслэж нийлүүлэлт хийж байх.

2. Оффисын электрон хэрэгслийн сонголт

- Ширээний компьютер ба монитор нь илүү их эрчим хүч, материал ашигладаг учир зөөврийн компьютер худалдан авах боломжийг юуны өмнө авч үзэх (ширээний компьютер зөөврийн компьютерээс 3-5 дахин их эрчим хүч хэрэглэнэ)
- Ажлын өдрийн болон ажлын 7 хоногийн төгсгөлд хувилагч өөрөө унтрах горимд тавих боломжтой 7 хоногийн цагтай хувилагч сонгох
- Олон хэрэглэгчтэй хувилагчийн хувьд 1 талд нь хэвлэсэн цаасны нөгөө талд хэвлэх зориулалтай 2 дахь тавиуртай байх
- Дахин боловсруулсан материалын орц ихтэй, дахин боловсруулсан материал ашиглаж болох хувилагч сонгох
- 2 талд нь хэвлэдэг принтерийг сонгох
- Дулаан боловсруулалттай цаас нь энгийн цааснаас 2 дахин үнэтэй учир энгийн цаас ашигладаг факс машин худалдаж авах, факс машинууд асаалттай хугацааныхаа маш бага хэсэгт факс явуулж, хүлээж авдаг учир "sleep" ба "standby" горимуудын үеийн эрчим хүч зарцуулалт бага машин, лазер буюу LED машины хувьд дахин боловсруулсан цаас ашиглах боломжтойг сонгох.

3. Бичиг хэргийн хэрэгслийн сонголт

- Ихэнх бал, балны савыг PVC хуванцраар хийдэг учир дахин боловсруулсан, эсвэл био задардаг материалаар хийсэн, цэнэглэж болдог, хоргүй бэхэн бал сонгож авах
- Олон тооны төрөл бүрийн цаасны хавчаарыг үйлдвэрлэхэд маш их түүхий эд, эрчим хүч зарцуулдаг. Тиймээс 100% дахин боловсруулсан материалаар хийгдсэн цаасны хавчаар сонгож авах
- Хотын хог хаягдлын урсгал дахь мөнгөн усны 88%, нийт кадмийн тал нь хаясан батерейнээс үүдэлтэй. Ийм учраас 1 удаагийн хэрэглээний батерейнаас зайлсхийж цахилгаанаар, эсвэл нарны эрчим хүчээр цэнэглэдэг батерей сонгох.
- Нарны эрчим хүчээр ажилладаг тооны машин ашиглах нь батерейны хэрэгцээг бууруулах ач холбогдолтой.
- Хлоргүй боловсруулсан, сул хлоржуулсан, дахин боловсруулсан, тогтвортой
- ойн менежменттэй хослуулж үйлдвэрлэсэн бичгийн цаас, дугтуй, картон, бусад цаасан материал худалдан авч байх, 00 зориулалтаар зөвхөн дахин боловсруулсан цаас худалдан авах.
- Цаасны цавууг цөөн тоогоор авч байх, эргүүлэн ашигладаг, хоргүй поливинилийн ацетат (PVA) балан цавуу хэрэглэх.
- Засагч шингэн (штрих)-ийг худалдаж авахгүй байх. (Засагч шингэн нь өөртөө их хэмжээний нүүрс устөрөгчийн нэгдлийг агуулдаг. Тэдгээр нь озоны давхарга цоороход болон дэлхийн дулааралд нөлөөлдөг ба оффисын синдром өвчний шалтгаан болдог).
- Цагаан самбар дээр бичих маркеруудыг сонгохдоо цэнэглэдэг маркеруудыг худалдан авах.

4. Бусад шаардлагатай худалдан авалтад мөрдөх

- Хуванцрын олон төрөл нь дахин боловсруулагддаггүй тул бүтээлчээр хандаж бага ашиглах, дахин боловсруулсан хуванцар сав хэрэглэх.
- Энгийн пластик уут газрын хөрсөнд 1000 жилийн турш шингэдэг ба түүхий нефтийг пластик болгох явцад маш их хэмжээний химийн бодис ялгардаг. Иймээс аль болох 100% задардаг, бордоо болдог уут худалдаж авах. Цаасан уут илүү ашиглах
- Улайсах гэрлийг худалдан авахгүй, орчин үеийн хамгийн үр ашигтай гэрэлтүүлэг болох LFC, LED лампууд авч байх
- Цэвэрлэгч бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хамгийн сөрөг нөлөөтэй, маш муугаар нөлөөлдөг учир ургамлын гаралтай, хүний эрүүл мэнд, байгальд учруулах хор, аюул багатай органик цэвэрлэгч бодисуудыг сонгох.
- Нэг удаагийн аяга, халбага, бусад хэрэгсэл худалдаж авахаас татгалзах

Ногоон оффисийн менежментийн аргачлал



НОГООН ОФФИСЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГАЧЛАЛ

1. Оффисын төхөөрөмжийн ашиглалт

1.1 Ажлын бус цагаар компьютер, мониторгыг заавал унтрааж байх, эсвэл автоматаар унтрах программ ашиглах (дундаж компьютерийн иж бүрдэл "sleep" горимд ойролцоогоор 35Вт, унтраалттай үедээ 3Вт зарцуулах ба зөвхөн тэжээлээс салгасан тохиолдолд хэрэглээ 0 болно),

1.2 Нэг цаг, түүнээс дээш хугацаагаар компьютер ашиглахгүй байх болон өөрт тохиромжтой гэж үзвэл үүнээс богино хугацаагаар ашиглахгүй байх тохиолдолд ч компьютерээ унтрааж байх,

1.3 Ширээний компьютер, мониторгийг ажиллахгүй орхисноос 15 минутын дараа "power save" горимд шилжихээр тохируулах.

1.4 Тухайн хэрэглэгчийн компьютерийг өөр хэн нэгэн зөвшөөрөлгүйгээр асаахгүй, ашиглахгүй, горимыг өөрчлөхгүй байх бодлогыг хэрэгжүүлэх.

1.5 Принтер, хувилагчийг:

- Хэрэглээгүй үедээ, ажлын цаг дуусахад унтрааж байх,
- Хэрэгцээндээ зохицуулж "sleep" горимд тохируулах,
- Print Preview үйлдлийг ашиглан хуудасны байршил, хэлбэрийг хянаж байх,
- 1 хуудсанд илүү мэдээлэл багтаахын тулд хүрээ, үсгийн шрифтийг тохируулж байх

- Хор, тонер хэмнэлттэй тохиргоог ашиглах,

- Хор, тонерыг дахин ашиглах, цэнэглэх

- Буурцагны гаралтай хор хэрэглэж байх

1.6 Сканерийг зөвхөн хэрэглэх шаардлагатай үед л асааж, бусад үед унтрааж байх.

1.7 Хог хаягдлын урсгал дахь мөнгөн усны 90%, нийт кадмийн тал нь хаясан батареинээс үүдэлтэй. Иймээс 1 удаагийн хэрэглээний батареинаас зайлсхийж цахилгаанаар, аль эсвэл нарны эрчим хүчээр цэнэглэдэг батарей хэрэглэх.

2. Бичиг хэргийн материалын ашиглалт

1.1 Цаасыг хамгийн бага ашиглах менежмент хэрэгжүүлэх. Үүнд:

- Цаасны 2 талд хэвлэх, хувилах,
- Ноорог цаасны нөгөө талд хэвлэж ашиглах,
- Дахин боловсруулсан материалаар хийгдсэн буюу хлоргүй боловсруулсан цаас ашиглах.
- "Гэрчилгээ", "Өргөмжлөл", "Батламж" гэх мэтийг өгөхийн оронд өөр цаас бага хэрэглэх боломжуудыг судлах, аль болох хэмжээг нь багасгах

- Компьютертэй ямар ч ажилтан ширээний календарь худалдаж авах шаардлагагүй.

- Сургалт, семинарын үеэр цаасан самбар (fleepchart) аль болох бага ашиглах, сургалтын материалыг цаасан дээр бичиж тараахгүй, CD-д бичиж, эсвэл веб хуудсаар тараах,

- Бичиг баримт хадгалалтад их хэмжээний цаас хоосон үрдэг. Цаасан материалыг хадгалахад гэрэлтүүлэгч, агааржуулагчтай орон зай, шошгожуулалт хэрэгтэй. Энэ бүгд өндөр өртөгтэй ба орчинд сөрөг нөлөө үзүүлдэг. Иймээс аль болох бичиг баримтын эх хувийг хувилж электрон байдлаар хадгалахыг хичээх.

- Ажилтнууд зөөврийн хатуу диск, флаш диск ашиглаж байх,

- Электрон шуудан зэрэг цаасгүй харилцааны аргуудыг өргөн хэрэглэх, (ингэснээр цаас үйлдвэрлэл, хангалт, тээвэрлэлтийн болон шуудан харилцааны зардлыг хэмнэж, тэдгээрээс үүдэлтэй байгаль орчны нөлөөллийг бууруулна).

- Компьютерт бичихдээ үсгийн болон бичлэгийн хэмжээг зөв тохируулж хэвлэхэд хамгийн бага цаас зарцуулах.

- Төрөл бүрийн брошюр, урилга, мэндчилгээ, танилцуулгууд... гэх мэт маркетингийн материалуудыг хэвлэхдээ хэрэгцээ, шаардлага, байгаа нөөц бололцоог нарийн тооцож ухаалаг хандах,

- Аливаа файлыг, ялангуяа электрон шуудан, ноогийг хэвлэх, хувилахаас өмнө танд тухайн баримтын хуулбар заавал хэрэгтэй эсэхийг тунгааж байх

1.2 Цавууг аль болох хэрэглэхгүй байх, хэрвээ цаасны цавуу хэрэг болвол эргүүлэн ашигладаг, хоргүй поливинилийн ацетат (PVA) балан цавуу хэрэглэх.

3. Тээврийн менежмент

3.1 Авто машинуудын ашиглалтыг хамгийн оновчтой байдлаар зохион байгуулах

3.2 Авто хэрэгслийн бензин, түлшний тооцоог нарийн хөтөлж, хязгаарлалт тавих

3.3 Аялал зугаалгаар явахдаа аль болох цөөн машин хэрэглэх

4. Эрчим хүчний менежмент

4.1 Гэрэлтүүлэг

4.1.1 Байгалийн гэрэл сайн ашиглах: цонхоо цэвэрхэн байлгах,

4.1.2 Гэрлийн шил, ойлгогчийг цэвэрлэж байх

4.1.3 Улайсах гэрлүүдийг хэмнэлттэй гэрлээр солих (LED, CFL),

4.1.4 Хүнгүй өрөөнүүдийн болон өдрийн цагаар гэрлүүдийг унтрааж хэвших, автоматжуулах,

4.2 Халаалт

4.2.1 Өрөөнүүдэд тохируулгын термостат хаалт тавих замаар хамгийн бага шаардагдах температурыг тохируулж байх

4.2.2 Байрны дулаан алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах (цонх, хаалга, дээвэр, ханын дулаан алдагдлыг багасгах)

4.2.3 Барилгын хана, цонх, дээврийн болон халаалтын шугамын дулаалга стандартын дагуу байгаа эсэхэд хяналт тавих

Цаашид бид юу хийх вэ?


- “Ногоон хөгжлийн” үзэл баримтлалын талаар ярих биш, бодитой хэрэгжүүлэх:
- “Бохирдуулагч нь төлөх” хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх
- Олон талын оролцоог хангах
- Экосистемийн үйлчлэлийн төлбөрийн зарчмуудыг хэрэгжүүлэх
- Байгальд оруулах хөрөнгө оруулалтын зорилтуудыг тодорхой томъёолж, хэрэгжүүлэх
- Цэвэр үйлдвэрлэлийн туршлага, мэдлэгийг бусад олон компаниуд, түүний дотор байгаль орчны бохирдол их гаргадаг томоохон үйлдвэрлэгчдэд дамжуулах,
- ЦҮ амжилттай нэвтрүүлсэн, хөрөнгө оруулсан компаниудыг дэмжин урамшуулах механизм бий болгох,

Цаашид бид юу хийх вэ?

- ЦҮ-ийн хөрөнгө оруулалтын санхүүгийн эх үүсвэрүүдийг хөгжүүлэх,
- Төсвийн ногоон худалдан авалтын тогтолцоог бий болгох (ногоон бүтээгдэхүүнийг худалдан авалтаар дэмжих)
- Эко шошгожуулалтын тогтолцоог боловсронгуй болгох
- Байгаль орчны мэдээллийн баазыг өргөтгөх, бие даасан веб хуудас бий болгож хөгжүүлэх,
- Тэргүүний дэвшилтэт технологийг дэмжих,
- Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх:
- Бүтээгдэхүүний эко дизайн, амьдралын мөчлөгийн хандлага
- МҮХАҮТ, бусад байгууллагуудтай хамтран ажиллах



“Green horse” төсөл





Анхаарал хандуулсанд баярлалаа, талархлаа

Think Green



Act Green

ХАЯГ:

МҮХАҮТ, Цэвэр хөгжил, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих газар,
УБ хот, 17011, ХУД, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж,
МҮХАҮТ-ын байр

ИМЭЙЛ:

esco@mongolchamber.mn